

ГАН ХИЙЦ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улаанбаатар хот

2021.04.24

Ган хийц ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурлыг 2021 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 11:40 минут Zoom программын ашиглан хурлаа зохион байгуулллаа.

Хуралд: Хувьцаа эзэмшигч М.Даваасүрэн, Л.Чинбат, Лувсандорж нар оролцлоо. Хурал зохион байгуулагч О.Ууганцэцэг

Хуралд тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 72,63% буюу 176112 ширхэг хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн тул Компанийн тухай хуулийн дагуу хурлын ирц бүрдсэн гэж үзээд хурлыг эхлэв.

Хурлын даргаар Хувьцаа эзэмшигч М.Даваасүрэн, нарийн бичгийн даргаар О.Ууганцэцэг нарыг сонгож батлав.

Хурлын дарга хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дотоод журмыг тус тус танилцуулж, батлуулав. Хурлыг 11:50 минут эхэлж, 12:50 цагт дуусгахыг санал оруулж батлууллаа.

Бүх хэлэлцэх асуудлаа танилцуулж дуусаад санал хүсэлтээ хэлэх санал оруулж байна. /Хуралд оролцсон бүх гишүүд 100 хувь саналаар зөвшөөрөв

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулах КД 7,8,3 , КТ 62.1.9
2. Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан
4. ТУЗ-ийн 2021 оны зардлын төсөв, Компанийн 2021 оны захиргаа, үйлчилгээний зардлын төсвийг батлах /компанийн дүрэм 7.8.7, КТ 62.1.13/
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох КТ 62.1.7

Хэлэлцсэн нь:

Хэлэлцэх асуудлыг бүгдийг танилцуулсны дараа санал асуулгадаа орох уу. / 100 хувь дэмжив/

Хэлэлцэх асуудлын дараалалын дагуу мэдээллийг ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн танилцуулна.

Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулав.

2020 он дэлхий дахинд цар тахалтай холбоотой манай улсын хувьд барилгын салбарт хэнд хэцүү үе байсан хэдий ч Ган Хийц ХК-ийн хувьд амжилт бүтээлээр дүүрэн, гэрээт

ажлуудаа бүгдийг нь амжилттай дуусгаж хүлээлгэн өгч хэрэглэгч харилцагч нарынхаа итгэл, сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн жил байсан.

Гүйцэтгэх захирал Д.Оюунзулын хувьд компанийнхаа үйл ажиллагаатай бүрэн танилцаж, дотоод үйл ажиллагаагаа сайжруулах, ажилчидтайгаа ойлголцох, дотоод уур амьсгал, алба хоорондын уялдаа холбоог сайжруулахад ихээхэн анхаарч ажилласан байна. .

2020 оны хувьд ихэнхи аж ахуйн нэгжүүдийн хувьд хүндрэлтэй жил өнгөрсөн бол Засгийн газраас гаргасан зарим шийдвэрүүд нь аж ахуйн нэгжүүдэд бодит дэмжлэг болж тус хэмнэсэн мөнгөө хэрэгцээт зүйлдээ хөрөнгө оруулах боломжийг олгожээ.

Өнгөрсөн жилийн зорилгын биелэлт 100%, харин зорилтуудын биелэлт 80%-тай байна. 2020 оны зорилго, зорилтуудаа амжилттай биелүүлсэн гэж ТУЗ-ийн зүгээс дүгнэж байна.

Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулав.

ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар 2020 оны Санхүүгийн тайланг хархад Ган хийц ХК нь -273 833 744,59 төгрөгийн алдагдалтай гарсан тул энэ жил ногдол ашиг тараахгүй гэсэн ТУЗ-ийн шийдвэр гарсан.

ТУЗ-ийн хийсэн ажлын тайлан

Тайлан дараах чиглэлээр тайланг танилцуулав.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан
 - ТУЗ, дэргэдэх хороодын талаарх мэдээлэл
 - ТУЗ-ийн хурлын төлөвлөгөө
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019-2021 оны бүрэлдэхүүн
 - Аудитын хорооны хийсэн ажлын тайлан
 - Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл

ТУЗ-ийн 2021 оны зардлын төсөв, компанийн үйл ажиллагааны 2021 оны зардлын төсвийн талаар танилцуулав.

Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг хавсралтаар танилцуулж байна. Үйлдвэрлэлтийг 450 тонн буюу 2,85 тэрбум төгрөг төсөвлөсөн байна.

Цалинг орон тооны талаар манай компани үндсэн тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс анхаар ажиллаж байна. 2021 онд цалинг нэмээгүй урьд жилийн төсвөөр орж ирж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг 84,44 сая төгрөгөөр санал оруулсан байна. ТУЗ-ийн зарим зардлыг компанийн захиргааны зардалд оруулж төсөвлөсөн.

2021 онд дараах хөрөнгө оруулалтуудыг хийхээр төлөвлөж байна.

- Цехийн дээврийн засвар
- Цехийн дотоод засвар
- Тоног төхөөрөмжийн шинэчлэл
- Дулаан холболт

- Оффисийн 00 болон кордиор засвар

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Компанийн тухай хууль болон компанийн дүрмийн заалтуудыг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хоёр жилд нэг удаа сонгох учиртай үүнтэй холбоотойгоор Хараат гишүүдэд 6 хүний нэр дэвшиж байна.

Үүнд: М.Даваасүрэн

Б.Эрдэнэбаяр

Ц.Пүрэвжаргал

Э.Долгорсүрэн

Ц.Хангай

П.Төвсанаа

Хараат бус гишүүнд

Д.Энхбаатар

Ц.Жанлав

Б.Гантулга

Д.Сайнбаяр нарын нэрийг дэвшүүлж байна.

Та бүхэнд анкетыг хавсаргасан тул танилцана уу. Ихэнх хүмүүс маань олон жил идэвхтэй ажиллаж байгаа хүмүүс байна.

М.Даваасүрэн: Анхаарал хандуулсан баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал дууслаа та бүхэн санал хүсэлтээ хэлнэ үү.

Лувсандорж: санал хүсэлт байхгүй тул дэмжиж байна.

Чинбат: Хэлэлцэж байгаа асуудлууд бүгд тодорхой, танилцуулагдсан тул татгалзах, асууж тодруулах зүйл байхгүй байна. Дэмжиж байна.

М.Даваасүрэн: Өөр асууж тодруулах зүйл байна уу. Байхгүй бол Тооллогын комисс байгуулж, ажилд нь оруулъя. ТУЗ-ийн 03 дугаар сарын 01-ны өдрийн хурлаар тооллогын гишүүдэд дараах хүмүүсийг сонгосон.

Тооллогын комиссын даргаар Бичиг хэрэг архивын эрхлэгч Б.Нина

Гишүүд Эко цаг ХХК-ийн нягтлан бодогч Т.Мөнгөнчимэг

Маркетингийн менежер Э.Азхүү.

Тооллогын комисс дарга Б.Нина: та бүхэнд 2 төрлийн саналыг хуудас бөглөх линкийг та бүхэнд илгээж байна. Бөглөөд илгээнэ үү.

Саналын хуудас №1 Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дүгнэх, Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөв, компанийн үйл ажиллагааны төсөв

Саналын хуудас №2 ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Саналын хуудас бөглөхтэй холбоотой заавар өгөв.

Тооллогын комиссын дарга Б.Нина саналын дүн, тооллогын комиссын хурлын протокол, тогтоолыг уншиж танилцуулав. /протокол, тогтоолыг хавсаргав./

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр сонгогдсон М.Даваасүрэн, Б.Эрдэнэбаяр, Ц.Пүрэвжаргал, Э.Долгорсүрэн, П.Төвсанаа, Ц.Хангай, Хараат бус гишүүнээр Д.Энхбаатар, Ц.Жанлав, Б.Гантулга нарт Ажлын өндөр амжилт хүсч баяр хүргэе.

Шийдвэрлэсэн нь:

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэв.
2. 2021 оны ТУЗ-ийн зардлын төсвийг 84,443,800 төгрөгөөр, Компанийн үйл ажиллагааны 2021 оны төсвийг 582,094,355 төгрөгөөр батлав.
3. ТУЗ-ийн хараат гишүүдийг сонгох асуудлаар хуралд оролцогчийн олонхийн саналаар М.Даваасүрэн, Б.Эрдэнэбаяр, П.Төвсанаа, Ц.Пүрэвжаргал, Э.Долгорсүрэн, Ц.Хангай нарыг, ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох асуудлаар хуралд оролцогчийн олонхийн саналаар Д.Энхбаатар, Ц.Жанлав, Б.Гантулга нарыг тус тус томилов.

Хурлын дарга М.Даваасүрэн хувьцаа эзэмшигчийн саналын дүнг үндэслэн шийдвэрлэсэн асуудалтай холбогдон гарах хурлын тогтоолын төслийг баталж, хурлаас гаргаж буй тогтоолыг уншиж танилцуулснаар хурал өндөрлөв. / тогтоолыг хавсаргав./

Хувьцаа эзэмшигчдийн хурал 2021 оны 04 дүгээр сарын 24 өдрийн 12:50 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн :

Нарийн бичгийн дарга



О.Ууганцэцэг

Танилцсан:

Хурлын дарга



М.Даваасүрэн